



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫ СУДАЛГАА



Улаанбаатар хот

2025



МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫ СУДАЛГАА

Судалгааны ажлыг гүйцэтгэсэн:

Ашигт малтмал, газрын тосны газрын

Уул уурхайн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Цэгц

Уул уурхайн хэлтсийн мэргэжилтэн

Д.Гүрнээбазар

Ашигт малтмал, газрын тосны газар
Монгол Улс, Улаанбаатар хот 15170,
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3,
Засгийн газрын XII байр, Баруун жигүүр
Утас: 976-51-263920

Цахим шуудан: info@mrpam.gov.mn

Цахим хаяг: mrpam.gov.mn

АГУУЛГА

1. УДИРТГАЛ.....	6
1.1. Судалгааны хамрах хүрээ.....	6
1.2. Судалгааны арга.....	8
1.2.1. Судалгааны асуулт.....	8
2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН.....	10
3. ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	13
3.1. Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдал.....	13
3.2. Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдал.....	14
3.3. Улс төрийн тогтвортой байдал.....	15
3.4. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал.....	16
3.5. Байгаль орчны хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал.....	17
3.6. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал.....	19
3.7. Уул уурхайн салбарын татварын орчин.....	20
3.8. Дэд бүтцийн хөгжил.....	21
3.9. Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавх.....	22
3.10. Амьдрах орчны аюулгүй байдал.....	23
3.11. Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал.....	24
3.12. Төрөөс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө.....	25
3.13. Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа.....	26
3.14. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж.....	28
3.15. Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа.....	29
3.16. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад хялбар байдал.....	30
3.17. Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлага.....	31
3.18. Уул уурхайн салбарын авлигаас ангид байдал.....	32
3.19. Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар.....	34
3.20. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломж.....	35
4. ДҮГНЭЛТ.....	37
5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	39

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Үйл ажиллагааны чиглэл	6
Зураг 2. Хөрөнгө оруулалт авсан хэлбэр	7
Зураг 3. Үйл ажиллагаа явуулсан жил	7
Зураг 4. Ашигт малтмалын төрөл.....	8
Зураг 5. Монгол Улсын Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ.....	12
Зураг 6. Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдлын үнэлгээ.....	13
Зураг 7. Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах санал	14
Зураг 8. Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдлын үнэлгээ.....	14
Зураг 9. Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдлыг сайжруулах санал	15
Зураг 10. Улс төрийн тогтвортой байдлын үнэлгээ.....	15
Зураг 11. Улс төрийн тогтвортой байдлыг сайжруулах санал	16
Зураг 12. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал.....	16
Зураг 13. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчныг сайжруулах санал	17
Зураг 14. Байгаль орчны хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал	18
Зураг 15. Байгаль орчны хууль эрхзүйн орчныг сайжруулах санал.....	18
Зураг 16. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал.....	19
Зураг 17. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийн хамгаалалтыг сайжруулах санал	19
Зураг 18. Уул уурхайн салбарын татварын орчин.....	20
Зураг 19. Уул уурхайн салбарын татварын орчныг сайжруулах санал	21
Зураг 20. Дэд бүтцийн хөгжил	21
Зураг 21. Дэд бүтцийг хөгжүүлэх санал	22
Зураг 22. Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавх	22
Зураг 23. Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавхыг сайжруулах санал	23
Зураг 24. Амьдрах орчны аюулгүй байдал.....	23
Зураг 25. Амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулах санал.....	24
Зураг 26. Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал.....	24
Зураг 27. Газрын харилцаа, түүний зохицуулалтыг сайжруулах санал	25
Зураг 28. Төрөөс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө	26


Зураг 29. Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах төрийн бодлогод оруулах санал.....	26
Зураг 30. Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа.....	27
Зураг 31. Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааг сайжруулах санал.....	27
Зураг 32. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийн үнэлгээ	28
Зураг 33. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийг сайжруулах санал.....	29
Зураг 34. Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааны үнэлгээ.....	29
Зураг 35. Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааг сайжруулах санал	30
Зураг 36. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад хялбар байдлын үнэлгээ	30
Зураг 37. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авах ажиллагааг хялбаршуулах санал	31
Зураг 38. Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлагын үнэлгээ	32
Зураг 39. Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлагыг сайжруулах санал	32
Зураг 40. Уул уурхайн салбарын авлигаас ангид байдлын үнэлгээ	33
Зураг 41. Уул уурхайн салбарыг авлигаас ангид байлгах санал	33
Зураг 42. Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарын үнэлгээ.....	34
Зураг 43. Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарыг сайжруулах санал	35
Зураг 44. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломжийн үнэлгээ.....	35
Зураг 45. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх санал	36

1. УДИРТГАЛ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах санал боловсруулах

1.1. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Хөрөнгө оруулалтын орчны судалгаанд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг чиглэл тус бүрийн байгууллагуудыг хамруулахыг зорьсон бөгөөд нийт 864 байгууллага хамрагдсан.




Зураг 1. Үйл ажиллагааны чиглэл

Судалгаанд оролцсон байгууллагуудаас ашигт малтмалын геологийн эрэл, хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд 85.0% нь байсан бол баяжуулалт, боловсруулалт, худалдаа, үйлчилгээ, өрөмдлөг тэсэлгээ, хөрөнгө оруулалт болон бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд 15.0%-ийг бүрдүүлсэн.

Дээрх байгууллагуудын хөрөнгө оруулалт оруулсан байдлыг авч үзвэл 66.4% буюу ихэнх нь өөрийн хөрөнгийг төсөлдөө зарцуулсан бол 22.0% нь гадаадын хөрөнгө оруулалтыг оруулж, 6.6% нь банк санхүүгийн байгууллагаас зээл авч, 5.0% нь хөрөнгийн зах зээл, төрийн хөрөнгө оруулалт, бонд, өрийн бичиг, концесс, гэрээ болон бусад байдлаар хөрөнгө оруулжээ.


ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ АВСАН ХЭЛБЭР




Зураг 2. Хөрөнгө оруулалт авсан хэлбэр

Үйл ажиллагаа явуулсан хугацааны хувьд байгуулагдаад удаагүй буюу 1-ээс 3 жил болж байгаа аж ахуйн нэгж 21.5%, 4-өөс 6 жил болж байгаа компаниуд 19.0%, 7-оос 10 жил болж байгаа аж ахуйн нэгж 22.1%-ийг эзэлж, 11-ээс 14 жил аж ахуй эрхэлж буй байгууллагууд 15.7%, 15-аас дээш жил үйл ажиллагаа эрхэлсэн туршлагажсан байгууллагууд 21.6%-ийг тус тус бүрдүүлсэн байна.

Үйл ажиллагаа явуулсан жил



Зураг 3. Үйл ажиллагаа явуулсан жил



Зураг 4. Ашигт малтмалын төрөл

Алтны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд хамгийн их хувь буюу 34.0%-ийг эзэлж, нүүрсний уурхай 18.4%, хайлуур жоншны уурхай 17.7%-ийг бүрдүүлсэн. Үлдсэн хэсгийг нь төмөр, барилгын материал, гянтболд, зэс, цайр, хар тугалга болон бусад төрлийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд бүрдүүлсэн байна.

1.2. СУДАЛГААНЫ АРГА

Судалгааны ажлыг асуулгын аргаар авч, хөрөнгө оруулалтын орчны чиглэлийн асуултуудад үнэлгээ өгөх байдлаар хариултуудыг авч тухайн асуудлыг сайжруулах арга замын талаар санал авлаа.

1.2.1. Судалгааны асуулт

Судалгааны асуулга нийтдээ 27 асуулттай бөгөөд үүнээс 5 асуулт нь ерөнхий мэдээлэл авах асуулт, үлдсэн 22 нь үндсэн асуулт байсан. Үндсэн асуултуудаас 20 асуулт нь уул уурхайн хөрөнгө оруулалтын орчинд үнэлгээ өгөх хариулт болон сайжруулах саналыг авсан бол 1 асуулт нь өмнөх асуултуудад ороогүй чиглэл байвал санал өгч болохоор, 1 асуулт нь энэхүү судалгааны ажлыг цаашид сайжруулахад юу хийх талаар санал авахаар зохиогдсон. Асуултуудыг боловсруулахдаа олон улсад уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчныг үнэлэхэд хэрэглэдэг үзүүлэлт болон манай орны нөхцөл байдалд тохируулсан асуултыг бэлтгэсэн болно.

Хөрөнгө оруулалтын орчныг үнэлж өгч, сайжруулах санал өгөх асуултууд:

1. Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдал
2. Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдал
3. Улс төрийн тогтвортой байдал
4. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал
5. Байгаль орчны хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал
6. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал
7. Уул уурхайн салбарын татварын орчин
8. Дэд бүтцийн хөгжил
9. Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавх
10. Амьдрах орчны аюулгүй байдал
11. Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал
12. Төрөөс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө
13. Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа
14. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж
15. Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа
16. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад хялбар байдал
17. Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлага
18. Уул уурхайн салбарын авлигаас ангид байдал
19. Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар
20. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломж

Санал асуулгад оролцогч нь дээрх 20 үзүүлэлт тус бүрт өөрийн байгууллагын үйл ажиллагаа явуулж буй одоогийн байдлыг бодолцон үзэж дараах 5 хариултын аль нэгийг сонгож үнэлэлт өгөхөөр зохицуулсан.

1. Маш муу
2. Муу
3. Дунд зэрэг
4. Сайн
5. Маш сайн

Асуулгын хариултыг геологи, уул уурхайн мэдээллийн системээр дамжуулан хүлээн авсан.

2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчинд 100 хүртэлх оноогоор үнэлэлт өгсөн. Судалгаанд оролцогчдоос ирүүлсэн хариултыг үнэлгээ тус бүрийн хувийн жинг гаргаж, жигнэсэн дундаж гаргах байдлаар тооцоолж нэгдсэн үнэлгээг тодорхойлсон.

Үнэлгээний 5 ангилал нь 100 онооны системд дараах онооны хамааралтай байхаар тооцоолсон.

- маш муу үнэлгээ нь 34 хүртэл оноо,
- муу үнэлгээ нь 34-өөс 50 оноо,
- дунд үнэлгээ нь 50-аас 66 оноо,
- сайн үнэлгээ нь 66-аас 84 оноо,
- маш сайн үнэлгээ нь 84-өөс дээш оноо

2025 оны хувьд нэгдсэн дүнгээр Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин **53.5** оноо авч **“Дунд”** гэсэн дүнтэй гарсан байна. Судалгааны асуултуудаас маш сайн, сайн, маш муу үзүүлэлттэй асуулт гараагүй бөгөөд дунд ангилалд 14 үзүүлэлт, муу ангилалд 6 үзүүлэлт хамрагдав.

Дунд ангилалд өндөр оноо авсан нь Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдал /61.2 оноо/, Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдал /59.2 оноо/, Байгаль орчны хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал /57.5 оноо/ байсан бол Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар /57.3 оноо/ гэсэн асуултууд нь дунд үзүүлэлт дотроо дээгүүр эрэмбэлэгдлээ. Харин Амьдрах орчны аюулгүй байдал /55.6 оноо/, Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа /54.9 оноо/, Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал /54.6 оноо/, Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал /54.4 оноо/, Уул уурхайн салбарын татварын орчин /54.0 оноо/ асуулт дунд дотроо дундуур эрэмбэлэгдэж Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад хялбар байдал /53.9 оноо/, Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж /53.8 оноо/, Уул уурхайн салбарын авлигаас ангид байдал /53.5 оноо/, Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавх /52.8 оноо/, Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломж /52.2 оноо/ гэсэн асуултууд нь дунд ангилалдаа доогуур жагсжээ. Дээрхээс Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавх, Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах

боломж гэсэн 2 асуулт нь 2024 онд “Муу” үнэлгээтэй 50.8-51.8 оноо авч байсан бол тус бүр 1-1.4 оноо нэмэгдэж дунд ангилалд орсон байна.

Муу ангилалд орсон үзүүлэлтээс хамгийн тааруу дүн үзүүлсэн нь Улс төрийн тогтвортой байдал /46.0 оноо/ бол үүний дараа Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлага /48.4 оноо/ орсон. Дараагийн түвшний тааруухан үзүүлэлт нь Дэд бүтцийн хөгжил /49.4 оноо/, Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа /49.7 оноо/, Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал /49.9 оноо/ байсан бол муу ангилал дотроо дээгүүр үзүүлэлттэй байгаа нь Төрөөс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө /50.8 оноо/ байв.

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ




Зураг 5. Монгол Улсын Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ

3. ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.1. ГЕОЛОГИЙН МЭДЭЭЛЛИЙГ ОЛЖ АВАХ БОЛОМЖ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдал “Дунд” буюу 59.2 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 59.8% нь дунд зэрэг, 17.5% нь сайн, 10.4% нь муу, 8.9% нь маш муу, 3.4% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 6. Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдлын үнэлгээ


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1474 сайжруулах санал хүсэлтээс харахад 550 санал буюу 37.3% нь цахимжуулж, онлайнаар үзэх, авах боломжтой болгох, 488 санал буюу 33.1% нь мэдээллийн сан, сайтын мэдээллийг шинэчлэх, сайжруулах, 349 санал буюу 24.9% нь нээлттэй, ил тод болгох саналыг ирүүлжээ.



Зураг 7. Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах санал

3.2. ГЕОЛОГИ, ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮР ДҮН, ТЭДГЭЭРИЙН ҮНЭМШИЛТЭЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд геологи, хайгуулын ажлын үнэмшил **“Дунд”** буюу 61.2 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 60.3% нь дунд зэрэг, 22.1% нь сайн, 8.0% нь муу, 6.8% нь маш муу, 2.8% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 8. Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдлын үнэлгээ

Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 864 сайжруулах санал хүсэлтээс харахад 220 санал буюу 25.5% нь ажил хийх боломжийг хангах, хөрөнгө санхүүгээр дэмжих, 192 санал буюу 22.2% нь хяналтыг сайжруулах, баталгаажуулах, хариуцлагыг өндөржүүлэх, 143 санал буюу 16.6% нь мэргэжлийн хүнээр чанартай, нарийвчилж гүйцэтгэх, 136 санал буюу 15.7% нь мэргэжлийн байгууллагыг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх, 108 санал буюу 12.5%


нь сургалт, гарын авлага, стандарт бий болгох, 65 санал буюу 7.5% нь ил тод, нээлттэй болгох саналыг ирүүлжээ.



Зураг 9. Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдлыг сайжруулах санал

3.3. УЛС ТӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд улс төрийн тогтвортой байдлын үнэлгээ **“Мүү”** буюу 46.0 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 40.9% нь дунд зэрэг, 27.2% нь муу, 25.3% нь маш муу, 5.2% нь сайн, 1.4% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 10. Улс төрийн тогтвортой байдлын үнэлгээ

Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 864 сайжруулах санал хүсэлтээс харахад 223 санал буюу 25.8% нь бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулах, 203 санал буюу 23.5% нь салбарыг улс төр, намаас ангид байлгах, хамаарлыг багасгах, 127 санал буюу 14.7% нь тогтолцоог өөрчлөх, 125 санал буюу 14.5% нь


удирдах болон гүйцэтгэх албан тушаалд мэргэжлийн хүнийг томилж, тогтвортой ажиллуулах, 104 санал буюу 12.0% нь ЗГ, төрийн байгууллага тогтвортой байх, 41 санал буюу 4.7% нь улс төрчдийн хариуцлагыг сайжруулах, 34 санал буюу 3.9% нь хууль хэрэгжүүлэх саналыг ирүүлжээ.



Зураг 11. Улс төрийн тогтвортой байдлыг сайжруулах санал

3.4. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧНЫ ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдлын үнэлгээ **“Дунд”** буюу 54.4 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 58.1% нь дунд зэрэг, 19.7% нь муу, 10.9% нь маш муу, 9.0% нь сайн, 2.3% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 12. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 879 сайжруулах санал хүсэлтээс харахад 251 санал буюу 28.6% нь батлагдсан хуулийг сурталчлан таниулах, сайн хэрэгжүүлэх, хяналтыг сайжруулах, 192 санал буюу 21.8% нь багасгах, хялбаршуулах, бодит байдалтай уялдуулах, 174 санал буюу 19.8% нь мэргэжлийн судалгаа, хүмүүсийн саналыг авах, 146 санал буюу 16.6% нь хууль тогтоомжуудын уялдаа холбоог сайжруулах, 83 санал буюу 9.4% нь тодорхой, ойлгомжтой болгох, 33 санал буюу 3.8% нь олон улсын жишиг судлах саналыг ирүүлжээ.



Зураг 13. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчныг сайжруулах санал

3.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧНЫ ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд байгаль орчны хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдлын үнэлгээ **“Дунд”** буюу 57.5 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсод муу үнэлгээ өгөөгүй бөгөөд 66.9% нь дунд зэрэг, 15.9% нь маш муу, 15.5% нь сайн, , 1.7% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 14. Байгаль орчны хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 3394 сайжруулах санал хүсэлтээс харахад 822 санал буюу 24.2% нь орон нутгийн оролцоог багасгах, 573 санал буюу 16.9% нь ААН-үүдээс ирүүлсэн туршлага, саналд үндэслэн хууль дүрмээ сайжруулах, 531 санал буюу 15.6% нь оновчтой, тодорхой болгох, 421 санал буюу 12.4% нь хууль хоорондын болон дүрэм, журмыг уялдаатай болгох, 399 санал буюу 11.8% нь хуулиа хэрэгжүүлдэг, хариуцлагатай байх, 268 санал буюу 7.9% нь нөхөн сэргээлтэд анхаарах, 171 санал буюу 5.0% нь хялбаршуулах, 160 санал буюу 4.7% нь хууль тогтоомжийг сурталчлах саналыг ирүүлжээ.



Зураг 15. Байгаль орчны хууль эрхзүйн орчныг сайжруулах санал

3.6. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ХУУЛЬ ЁСНЫ ЭРХ АШГИЙГ ХАМГААЛСАН БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдлын үнэлгээ **“Муу”** буюу 49.9 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 50.6% нь дунд зэрэг, 25.6% нь муу, 16.7% нь маш муу, 6.1% нь сайн, 1.0% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 16. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1439 сайжруулах санал хүсэлтээс харахад 411 санал буюу 28.6% нь хөрөнгө оруулагчдыг дэмжих, хамгаалах, ажиллах нөхцөлөөр хангах, 410 санал буюу 28.5% нь хууль тодорхой, тогтвортой байх, 408 санал буюу 28.4% нь хууль эрх зүйн орчныг сайжруулах, 162 санал буюу 11.3% нь мэдээлэл сурталчилгаа хийх саналыг ирүүлжээ.



Зураг 17. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийн хамгаалалтыг сайжруулах санал

3.7. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ТАТВАРЫН ОРЧИН

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд уул уурхайн салбарын татварын орчны үнэлгээ **“Дунд”** буюу 54.0 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 55.3% нь дунд зэрэг, 19.9% нь муу, 12.3% нь маш муу, 10.5% нь сайн, 2% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 18. Уул уурхайн салбарын татварын орчин


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 2777 сайжруулах санал хүсэлтээс харахад 518 санал буюу 18.7% нь давхардуулж авахгүй байх, 518 санал буюу 18.7% нь татварын хувь хэмжээг багасгах, 402 санал буюу 14.5% нь уян хатан татварын системтэй болох, 362 санал буюу 13.0% нь татвар ногдуулах аргачлалыг сайжруулах, 353 санал буюу 12.7% нь АМНАТ-ыг бууруулах, 184 санал буюу 6.6% нь хуулийн заалтыг хянах, сайжруулах, ойлгомжтой болгох, 156 санал буюу 5.6% нь татварын орчныг тогтвортой байлгах, 124 санал буюу 4.5% нь татварын нэгдсэн бодлогыг бий болгох, 116 санал буюу 4.2% нь хэрэгжилтийг сайжруулж, мэдээлэл сурталчилгаа хийх саналыг ирүүлжээ.



Зураг 19. Уул уурхайн салбарын татварын орчныг сайжруулах санал

3.8. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд дэд бүтцийн хөгжлийн үнэлгээ “Муу” буюу 49.4 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 47.2% нь дунд зэрэг, 29.1% нь муу, 16.2% нь маш муу, 6.4% нь сайн, 1.2% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 20. Дэд бүтцийн хөгжил

Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1807 сайжруулах санал хүсэлтээс харахад 362 санал буюу 20.0% нь төрийн бодлого, урт хугацааны төлөвлөгөөгөөр хөгжүүлэх, 304 санал буюу 16.8% нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, 291 санал буюу 16.1% нь эрчим хүчний эх үүсвэрийг


нэмэгдүүлэх, 256 санал буюу 14.2% нь авто зам барих, засвар үйлчилгээг сайжруулах, 233 санал буюу 12.9% нь төмөр зам барих, 200 санал буюу 11.1% нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, 122 санал буюу 6.8% нь боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, зохицуулалтыг сайжруулах саналыг ирүүлжээ.



Зураг 21. Дэд бүтцийг хөгжүүлэх санал

3.9. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХҮРЭЛЦЭЭ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавхын үнэлгээ **“Дунд”** буюу 52.8 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 55.1% нь дунд зэрэг, 24.0% нь муу, 11.6% нь маш муу, 7.6% нь сайн, 1.7% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 22. Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавх

Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1611 сайжруулах санал хүсэлтээс харахад 387 санал буюу 24.0% нь боловсон хүчнийг сайн бэлдэх, 353 санал буюу 21.9% нь ажиллах нөхцөлийг сайжруулах, цалин хөлсийг

нэмэгдүүлэх, 295 санал буюу 18.3% нь мэргэшүүлэх сургалтын төвүүдийн үйл ажиллагааг дэмжих, чанаржуулах, 241 санал буюу 15.0% нь мэргэжлийн сургалт зохион байгуулах, 152 санал буюу 9.4% нь сургалтын системийг сайжруулах, 137 санал буюу 8.5% нь сайн сурталчлах саналыг ирүүлжээ.



Зураг 23. Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавхыг сайжруулах санал

3.10. АМЬДРАХ ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд амьдрах орчны аюулгүй байдлын үнэлгээ **“Дунд”** буюу 55.6 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 61.2% нь дунд зэрэг, 16.9% нь муу, 11.0% нь сайн, 9.5% нь маш муу, 1.4% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 24. Амьдрах орчны аюулгүй байдал

Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1441 сайжруулах санал хүсэлтээс харахад 549 санал буюу 38.1% нь дэд бүтцийг сайжруулах, 398 санал буюу 27.6% нь агаар, хөрсний бохирдлыг үе шаттай бууруулах, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын хяналтыг сайжруулах, 355 санал буюу 24.6% нь


хүнсний аюулгүй байдалд анхаарах, 139 санал буюу 9.6% нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх саналыг ирүүлжээ.



Зураг 25. Амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулах санал

3.11. ГАЗРЫН ХАРИЛЦАА, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд газрын харилцааны зохицуулалтын байдал **“Дунд”** буюу 54.6 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 59.0% нь дунд зэрэг, 19.3% нь муу, 10.3% нь маш муу, 9.8% нь сайн, 1.5% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 26. Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал

Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1877 сайжруулах санал хүсэлтээс харахад 328 санал буюу 17.5% нь төлөвлөлт зохион байгуулалтыг сайн хийх, 308 санал буюу 16.4% нь газрын тухай хуулийг сайжруулах мөн ард иргэдэд сурталчилж таниулах, 278 санал буюу 14.8% нь газрын харилцааны


байгууллагуудыг нэгдсэн системтэй болгох, 256 санал буюу 13.6% нь газрын төлбөрийн гэнэтийн өсөлт мөн давхар төлбөр төлөхийг зогсоох, 194 санал буюу 10.3% нь авлигал, хүнд суртлыг арилгах, 191 санал буюу 10.2% нь шуурхай байх, 148 санал буюу 7.9% нь байгууллага хоорондын уялдааг сайжруулах, 138 санал буюу 7.4% нь мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах, саналыг ирүүлжээ.



Зураг 27. Газрын харилцаа, түүний зохицуулалтыг сайжруулах санал

3.12. ТӨРӨӨС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ТАЛ ДЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөөний үнэлгээ **“Мүү”** буюу 50.8 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 54.2% нь дунд зэрэг, 24.9% нь муу, 14.5% нь маш муу, 5.1% нь сайн, 1.4% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 28. Төрөөс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1917 сайжруулах санал хүсэлтээс харахад 412 санал буюу 21.5% нь ААН-ийг дэмжсэн бодлого баримтлах, 331 санал буюу 17.3% нь хууль эрх зүйн орчныг сайжруулах, 283 санал буюу 14.8% нь бодлогоо тодорхой болгох, 292 санал буюу 15.2% нь бодлого тогтвортой байх, 250 санал буюу 13.0% нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, 175 санал буюу 9.1% нь орон нутгийн эрх мэдлийг хязгаарлах, 141 санал буюу 7.4% нь урт хугацаатай, хүү багатай дэмжих зээл гаргах саналыг ирүүлжээ.



Зураг 29. Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах төрийн бодлогод оруулах санал

3.13. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН УУЛ УУРХАЙН КОМПАНИУД ХООРОНДЫН ХАРИЛЦАА

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа “**Дунд**” буюу 54.9 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 59.8% нь дунд зэрэг, 16.3% нь муу, 11.6% нь маш муу, 10.4% нь сайн, 1.9% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 30. Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа

Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1995 сайжруулах санал хүсэлтээс харахад 364 санал буюу 18.2% нь хүнд суртлыг арилгах, 355 санал буюу 17.8% нь цахимаар үйлчилгээ үзүүлэх, 295 санал буюу 14.8% нь зааварчилгаа, зөвлөмж өгөх, бичиг баримтын асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэх, 280 санал буюу 14.0% нь төрийн албан хаагчдын хариуцлагыг нэмэгдүүлэх, харилцаа, хандлагыг сайжруулах, 199 санал буюу 10.0% нь нэгдмэл ойлголттой, нэгдсэн системтэй болох, 190 санал буюу 9.5% нь хууль, дүрэм, журмаа мөрдөж ажиллах, 161 санал буюу 8.1% нь төрийн оролцоог багасгах, 120 санал буюу 6.0% нь хууль журмаа сайжруулах саналыг ирүүлжээ.



Зураг 31. Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааг сайжруулах санал

3.14. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ БОЛОМЖ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийн үнэлгээ **“Дунд”** буюу 53.8 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 54.7% нь дунд зэрэг, 18.3% нь муу, 13.9% нь маш муу, 11.2% нь сайн, 1.9% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 32. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийн үнэлгээ


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1900 сайжруулах санал хүсэлтээс харахад 359 санал буюу 18.9% нь орон нутгийн оролцоог багасгах, 354 санал буюу 18.6% нь хуулиас давсан дарамт шахалтыг зогсоох, зөвхөн хуулийн хүрээнд хамтран ажиллах, 350 санал буюу 18.4% нь бодлогоо зөв тодорхойлж, нэг ойлголт, хандлагаар хамтарч ажиллах, 297 санал буюу 15.6% нь орон нутгийн удирдлагуудад мэргэжлийн сургалт, зөвлөгөө өгч байх, 205 санал буюу 10.8% нь мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, 153 санал буюу 8.1% нь мэдээ, мэдээллийг сурталчилж таниулах, 152 санал буюу 8.0% нь авлига, хүнд суртлыг арилгах саналыг ирүүлжээ.



Зураг 33. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийг сайжруулах санал

3.15. НУТГИЙН ИРГЭД БОЛОН УУЛ УУРХАЙН КОМПАНИУД ХООРОНДЫН ХАРИЛЦАА

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааны үнэлгээ **“Муу”** буюу 49.7 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 47.9% нь дунд зэрэг, 22.8% нь муу, 19.8% нь маш муу, 8.0% нь сайн, 1.5% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 34. Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааны үнэлгээ


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1734 сайжруулах санал хүсэлтээс харахад 406 санал буюу 23.4% нь уул уурхайн салбарыг таниулах, сурталчлах, ойлгуулах, 368 санал буюу 21.2% нь асуудлыг тодорхой болгож хуульчилж өгөх, 356 санал буюу 20.5% нь орон нутгийн эрх мэдлийг багасгах, 327 санал буюу 18.9% нь харилцан ойлголцож, хамтран ажилладаг байх, 242 санал буюу 14.0% нь иргэд хуулиа дагаж мөрдөж ухамсарлах, хуулийн мэдлэг олгох саналыг ирүүлжээ.



Зураг 35. Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааг сайжруулах санал

3.16. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ АВАХАД ХЯЛБАР БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас тусгай зөвшөөрөл авахад хялбар байдлын үнэлгээ “Дунд” буюу 53.9 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 58.9% нь дунд зэрэг, 18.3% нь муу, 12.4% нь маш муу, 8.4% нь сайн, 2.0% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 36. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад хялбар байдлын үнэлгээ


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 864 сайжруулах санал хүсэлтээс харахад 196 санал буюу 22.7% нь цахим болгох, 167 санал буюу 19.3% нь олон шат дамжлагыг цөөрүүлэх, 141 санал буюу 16.3% нь үйлчилгээг хуулийн хугацаанд хурдан шийдвэрлэх, 134 санал буюу 15.5% нь өргөдлөөр талбайг өгдөг байх, 115 санал буюу 13.3% нь хууль эрх зүйн орчныг сайжруулах, 46 санал буюу 5.3% нь ил тод, шударга явуулах, 65 санал буюу 7.5% нь хүнд суртал, ашиг сонирхлын зөрчлийг арилгах, саналыг ирүүлжээ.



Зураг 37. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авах ажиллагааг хялбаршуулах санал

3.17. ОЛОН НИЙТИЙН ЗҮГЭЭС УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАНДАЖ БАЙГАА ХАНДЛАГА

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлагын үнэлгээ “Муу” буюу 48.4 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 44.8% нь дунд зэрэг, 25.9% нь муу, 21.3% нь маш муу, 5.7% нь сайн, 2.3% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 38. Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлагын үнэлгээ


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 866 сайжруулах санал хүсэлтээс харахад 236 санал буюу 27.3% нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, 203 санал буюу 23.4% нь нийтэд бодит байдлыг ил тод, зөв мэдээллийг түгээх, 191 санал буюу 22.1% нь улстөржиж олон нийтийг турхирсан худал мэдээлэл тараах зэрэгт хяналт тавих, 139 санал буюу 16.1% нь хуулиар тодорхой нэгдсэн бодлоготой болох, 87 санал буюу 10.0% нь нөхөн сэргээлтийн ажлыг сайжруулах саналыг ирүүлжээ.



Зураг 39. Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлагыг сайжруулах санал


3.18. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН АВЛИГААС АНГИД БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас авлигаас ангид байдлын үнэлгээ **“Дунд”** буюу 53.5 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 56.3% нь дунд зэрэг, 19.2% нь муу, 13.2% нь маш муу, 9.2% нь сайн, 2.1% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 40. Уул уурхайн салбарын авлигаас ангид байдлын үнэлгээ


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1974 сайжруулах санал хүсэлтээс харахад 353 санал буюу 17.9% нь төрийн оролцоог багасгах, 275 санал буюу 13.9% нь хууль эрх зүйн орчныг сайжруулах, 271 санал буюу 13.7% нь хүнд суртлыг арилгах, 257 санал буюу 13.0% нь шат дамжлага, зөвшөөрлийн тоог багасгах, 252 санал буюу 12.8% нь хуулийн хүрээнд ажиллах, 233 санал буюу 11.8% нь авлига авсан албан хаагчид ногдуулах арга хэмжээг чангатгах, 163 санал буюу 8.3% нь нээлттэй ил тод болгох, 139 санал буюу 7.0% нь цахим болгох саналыг ирүүлжээ.



Зураг 41. Уул уурхайн салбарыг авлигаас ангид байлгах санал

3.19. ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ, ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ, БҮТЭЭГДЭХҮҮН, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгчийн хүрэлцээ, чанарын үнэлгээ “Дунд” буюу 57.3 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсдын 62.5% нь дунд зэрэг, 13.9% нь сайн, 13.1% нь муу, 8.8% нь маш муу, 1.7% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 42. Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарын үнэлгээ


Судалгаанд оролцогсодоос илгээсэн нийт 1645 сайжруулах санал хүсэлтээс харахад 358 санал буюу 21.8% нь чанараа сайжруулах, хариуцлагатай, хугацаандаа нийлүүлдэг байх, 319 санал буюу 19.4% нь дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, 247 санал буюу 15.0% нь мэргэжлийн боловсон хүчний чадавхийг сайжруулах сургалт, 244 санал буюу 14.8% нь хуулийн зохицуулалтыг сайжруулах, өндөр татвар, төлбөрийн дарамтыг багасгах, 160 санал буюу 9.7% нь уялдаа холбоог сайжруулах, 153 санал буюу 9.3% нь гэрээний нөхцөлийг илүү сайн чанартай болгох, 128 санал буюу 7.8% нь мэдээллээр хангах саналыг ирүүлжээ.



Зураг 43. Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарыг сайжруулах санал

3.20. УУЛ УУРХАЙН САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ, ХУВЬЦАА ЭЗЭМШИХ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ АВАХ БОЛОМЖ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломжийн үнэлгээ “Дунд” буюу 52.2 оноотой байна. Нийт судалгаанд оролцогсодын 56.4% нь дунд зэрэг, 23.6% нь муу, 12.4% нь маш муу, 5.8% нь сайн, 1.9% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 44. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломжийн үнэлгээ

Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1578 сайжруулах санал хүсэлтээс харахад 390 санал буюу 24.7% нь ил тод, нээлттэй болгох, 345 санал буюу 21.9% нь мэдээллийг хялбар, ойлгомжтой байдлаар нийтэд түгээх, олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, 343 санал буюу 21.7% нь мэдээллийг сайжруулах, 274 санал буюу 17.4% нь мэдээллийг цахим хэлбэрээр авах боломжтой болгох, 187 санал буюу 11.9% нь мэдээллийн нэгдсэн сан, платформ бий болгох саналыг ирүүлжээ.



Зураг 45. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх санал

4. ДҮГНЭЛТ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны 2025 оны байдлыг судалж үзээд дараах дүгнэлтийг гаргалаа.

- Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ **53.5** оноо буюу **“ДУНД”** гэсэн үнэлгээтэй байна.
- Үнэлгээг нэгтгэн гаргасан 20 үзүүлэлтээс “маш сайн”, “сайн” гэсэн үнэлгээ гараагүй байгаа нь хөрөнгө оруулалтын орчин таатай гэж үзэх боломжгүй байна. Мөн “маш муу” гэсэн үзүүлэлт илрээгүй нөхцөл байдал хэт хүндрээгүй байгааг илтгэж байна. Дунд ангилалд 14 үзүүлэлт, муу ангилалд 6 үзүүлэлт хамрагдав.
- Дунд ангилалд өндөр оноо авсан нь Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдал /61.2 оноо/, Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдал /59.2 оноо/, Байгаль орчны хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал /57.5 оноо/ байсан бол Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар /57.3 оноо/ гэсэн асуултууд нь дунд үзүүлэлт дотроо дээгүүр эрэмбэлэгдлээ. Амьдрах орчны аюулгүй байдал /55.6 оноо/, Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа /54.9 оноо/, Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал /54.6 оноо/, Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал /54.4 оноо/, Харин Уул уурхайн салбарын татварын орчин /54.0 оноо/ дунд үзүүлэлтийн дундуур эрэмжбэлэгдэж Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад хялбар байдал /53.9 оноо/, Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж /53.8 оноо/, Уул уурхайн салбарын авлигаас ангид байдал /53.5 оноо/, Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавх /52.8 оноо/, Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломж /52.2 оноо/ гэсэн асуултууд нь дунд ангилалдаа доогуур жагсжээ.
- Муу ангилалд орсон үзүүлэлтээс хамгийн тааруу дүн үзүүлсэн нь Улс төрийн тогтвортой байдал /46.0 оноо/ бол үүний дараа Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлага /48.4 оноо/ орсон. Дараагийн түвшний тааруухан үзүүлэлт нь Дэд бүтцийн хөгжил /49.4 оноо/, Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа /49.7 оноо/, Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал /49.9 оноо/ байсан бол муу ангилал дотроо дээгүүр

үзүүлэлттэй байгаа нь Төрөөс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө /50.8 оноо/ байв.

- Хамгийн өндөр үнэлгээтэй үзүүлэлт нь “Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдал” байгаа хэдий ч хяналт, хариуцлагын тогтолцоо сул, мэргэжлийн байгууллага, мэргэжилтний оролцоо хангалттай бус байгаагаас дунд үнэлгээг авсан байна. Дараагийн өндөр үнэлгээтэй “Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдал” үзүүлэлт нь мэдээлэл бүрэн цахимжаагүй, нээлттэй байдаггүй, мэдээллийн сан, сайтын мэдээлэл шинэчлэлт бага байгаа нь дунд үнэлгээ авахад нөлөөлжээ.
- Хамгийн муу үзүүлэлт нь “Улс төрийн тогтвортой байдал” болсон шалтгаан нь, эрх зүйн орчны байдал тааруу, салбарын үйл ажиллагаа улс төр, намын үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай болж, салбарыг мэргэжлийн бус хүн удирдаж, төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллахгүй, Засгийн газар, төрийн байгууллагын үйл ажиллагаа тогтвортой явагдахгүй, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт ихээр хийгдэж, улс төрчдийн хариуцлагагүй үйлдэл, хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас болжээ.
- Дараагийн тааруухан үзүүлэлтэд нь “Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлага” орж байгаа нь ард иргэдэд үнэн зөв бодит мэдээлэл очихгүй, улс төрч, төрийн бус байгууллага буруу ташаа мэдээлэл түгээж, популизм хийж байгаагийн зэрэгцээ хууль бус олборлолт, нөхөн сэргээлт хийдэггүй, хариуцлагатай уул уурхайг хангалттай хэмжээнд хөгжүүлэхгүй, салбарын хэмжээнд нэгдсэн бодлого өгүүлэгдэж байгаатай холбоотой.
- “Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал”-д хөрөнгө оруулагчдыг дэмжих, хамгаалах, ажиллах нөхцөлөөр хангах дэмжлэг сул, хууль эрх зүйн орчны тогтворгүй, тодорхой бус байдал, оролцогч талуудад мэдээлэл сурталчилгаа бага хийдэг зэрэг голлох шалтгаанууд нөлөөлсөн байна.

5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин 2025 оны байдлаар “Дунд” үнэлгээтэй болон үнэлгээний бүрэлдэхүүн үзүүлэлтүүд нь “маш сайн”, “сайн” үнэлгээнд хүрээгүй байгаа тул хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах шаардлагатай бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна.

- Салбарын болон холбогдох хуульд өөрчлөлт оруулж оролцогч талуудын эрх үүргийг давхардалгүй, уурхайн үйл ажиллагаа явуулахад хүндрэлгүй түргэн шуурхай болгох.
- Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийг сайжруулах, хайгуул ашиглалтын бүхий л үед гарч болзошгүй эрсдэл болон давуу талыг үнэн бодитоор иргэдэд мэдээлэх, таниулан сурталчлах.
- Засгийн газар, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг тогтвортой явуулахад анхаарч, салбарын үйл ажиллагааг нам, улс төрийн үйл ажиллагаанаас хамаарал багатай байлгах үйлдлийг бодлогын хэмжээнд авч хэлэлцэх.
- Орон нутгийн эрх мэдлийг багасгах.
- Улс орны эдийн засгийн тэргүүлэх чиглэл болох уул уурхайн салбарын хөгжлийг иргэдэд эерэг талаас нь таниулж, хэрэв уул уурхайн салбар зогсвол иргэд бидний амьдралд учрах эрсдэлийг эдийн засгийн утгаараа хэрхэн нөлөөлөх талаар тооцоо судалгаатайгаар мэдээлэх, ойлголтыг өгөх.
- Авто болон төмөр зам барих, засвар үйлчилгээг сайжруулах, ачаа эргэлтийг оновчтой зохион байгуулах, эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлж дэд бүтцийн хөгжлийг сайжруулах. Мөн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, зохицуулалтыг сайжруулах хэрэгцээ шаардлага их байна.
- Хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж улс төр, хууль эрхзүй, хүн ам зүйн эрсдэлээс хамгаалах зорилгоор эрхзүйн шинэтгэл хийх, гэнэтийн шийдвэр гаргалтаас зайлсхийх.
- Дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зэрэг ажлыг нэн тэргүүнд хийх шаардлагатай гэж үзлээ.